



БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН НЭГТГЭЛИЙН ТАНИЛЦУУЛГА

2021 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлан

БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН ГАЗАР

Монгол Улс, Улаанбаатар хот 15160, Чингэлтэй Дүүрэг, Бага тойруу 3, Засгийн газрын
IV байр. Утас: 51-261668

Агуулга

Хүснэгтийн жагсаалт.....	3
Зургийн жагсаалт.....	3
Товчилсон нэрсийн жагсаалт	4
Банк бус санхүүгийн байгууллагын салбарын ерөнхий төлөв байдал.....	5
Хууль, тогтоомж болон журмын өөрчлөлт, хэрэгжилт	7
“Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай” хуулийн 15 дугаар зүйлийн 15.4 дэх заалтын хэрэгжилт.....	7
“Зээлийн мэдээллийн тухай” хуулийн хэрэгжилт.....	7
“Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай” хуулийн хэрэгжилт ..	7
“Зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг тогтоох, төвлөрүүлэх журам”-ын хэрэгжилт	8
Статистик үзүүлэлтүүд	9
Харилцагчид, зээлдэгчид	9
Хувьцаа эзэмшигчид, ажилчид	9
Тархалт	11
Активын бүтэц, бүрэлдэхүүн, өөрчлөлт.....	12
Мөнгөн хөрөнгө.....	13
Богино хугацаат хөрөнгө оруулалт.....	13
Факторингийн тооцооны авлага.....	14
Өмчлөх бусад үл хөдлөх болон өмчлөх бусад хөрөнгө	14
Зээл.....	14
Аппликэйшн ашиглан зээл олгож байгаа ББСБ-ууд.....	17
Бусад хөрөнгө	18
Эргэлтийн бус хөрөнгө	18
Пассивын бүтэц, бүрэлдэхүүн, өөрчлөлт	19
Санхүүгийн эх үүсвэр	19
Дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагад төлөх өглөг	20
Бусад эх үүсвэр	20
ББСБ-аас гаргасан өрийн бичиг	21
Төслийн зээлийн санхүүжилт.....	21
Бусад өр төлбөр	22
Хувь нийлүүлсэн хөрөнгө.....	22
Бусад өмч, сангууд	23
Хуримтлагдсан ашиг	23
Хоёрдогч өглөг.....	24
Ашигт ажиллагаа	25
Зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд.....	27
Дүгнэлт	28

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1 ББСБ-уудын тоо мэдээлэл	5
Хүснэгт 2 Банкны салбартай харьцуулсан ерөнхий үзүүлэлтүүд /тэрбум төгрөгөөр/	5
Хүснэгт 3 ББСБ-уудын эрхэлж буй үйл ажиллагаа	5
Хүснэгт 5 Харилцагчдын мэдээлэл.....	9
Хүснэгт 6 Статистик мэдээлэл /5 жилээр/.....	9
Хүснэгт 7 ББСБ-ын мэдээлэл	10
Хүснэгт 8 Тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа.....	10
Хүснэгт 9 Улаанбаатар хотын ББСБ-уудын тархалт	11
Хүснэгт 10 Хөдөө орон нутгийн ББСБ-уудын тархалт	11
Хүснэгт 11 Активын үзүүлэлтүүд /сая төгрөгөөр/	12
Хүснэгт 12 Активын интервал /тэрбум төгрөгөөр/	12
Хүснэгт 13 Мөнгөн хөрөнгийн бүтэц /тэрбум төгрөгөөр/.....	13
Хүснэгт 14 Богино хугацаат хөрөнгө оруулалтын бүтэц /сая төгрөгөөр/.....	13
Хүснэгт 16 Факторингийн тооцооны авлагын ангилал /сая төгрөгөөр/.....	14
Хүснэгт 17 ӨБҮХХ болон ӨБХ-ийн бүтэц /сая төгрөгөөр/	14
Хүснэгт 18 Зээлийн бүтэц /тэрбум төгрөгөөр/	14
Хүснэгт 19 Олгосон болон төлөгдсөн зээл салбараар /сая төгрөгөөр/.....	16
Хүснэгт 20 Зээлийн ангилал /тэрбум төгрөгөөр/.....	17
Хүснэгт 21 Аппликэйшн ашиглан зээл олгож байгаа ББСБ-ууд.....	17
Хүснэгт 22 Зээл олгож буй аппликэйшнүүд.....	17
Хүснэгт 23 Мост мони аппликэйшнд холбогдсон ББСБ-ууд.....	17
Хүснэгт 24 Бусад хөрөнгийн бүтэц /сая төгрөгөөр/.....	18
Хүснэгт 25 Эргэлтийн бус хөрөнгийн бүтэц /тэрбум төгрөгөөр/	18
Хүснэгт 26 Пассивын үзүүлэлтүүд /сая төгрөгөөр/	19
Хүснэгт 27 Итгэлцлийн үйлчилгээ /тэрбум төгрөгөөр/	20
Хүснэгт 29 Дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагад төлөх өглөг /тэрбум төгрөгөөр/.....	20
Хүснэгт 30 Бусад эх үүсвэрийн бүтэц /сая төгрөгөөр/.....	20
Хүснэгт 32 ББСБ-аас гаргасан өрийн бичиг /мянган төгрөгөөр/.....	21
Хүснэгт 34 Төслийн зээл санхүүжилт /сая төгрөгөөр/.....	22
Хүснэгт 35 Бусад өр төлбөр /сая төгрөгөөр/	22
Хүснэгт 36 Хувьцаат капиталын бүтэц /сая төгрөгөөр/.....	22
Хүснэгт 37 ХНХ-ийн интервал /тэрбум төгрөгөөр/	23
Хүснэгт 38 Бусад өмч, сангуудын бүтэц /сая төгрөгөөр/	23
Хүснэгт 39 Хуримтлагдсан ашиг/алдагдал /тэрбум төгрөгөөр/.....	24
Хүснэгт 41 Орлого, үр дүнгийн тайлан /харьцуулсан, сая төгрөгөөр/.....	25
Хүснэгт 42 Орлого, үр дүнгийн тайлан /сая төгрөгөөр/	26
Хүснэгт 43 2021 оны эхний хагас жилийн валют арилжааны мэдээ /тэрбум төгрөгөөр/.....	26
Хүснэгт 44 ЗХШҮ /үзүүлэлт бүрээр/.....	27

Зургийн жагсаалт

Зураг 1 ББСБ-уудын тархалт.....	11
Зураг 2 Активын үзүүлэлтүүд сүүлийн 5 жилийн байдлаар /тэрбум төгрөгөөр/	12
Зураг 3 Мөнгөн хөрөнгийн бүтэц сүүлийн 5 жилийн байдлаар /тэрбум төгрөгөөр/	13
Зураг 4 Зээлийн багцын чанар /тэрбум төгрөгөөр/	15
Зураг 5 Зээлийн багцын чанар /хувиар/.....	15
Зураг 6 Олгосон зээл /хугацааны ангилалаар/	16
Зураг 7 Пассивын үзүүлэлтүүд сүүлийн 5 жилийн байдлаар /тэрбум төгрөгөөр/	19
Зураг 8 Итгэлцлийн үйлчилгээний өглөг /тэрбум төгрөгөөр/.....	20
Зураг 9 Бусад эх үүсвэрийн үлдэгдэлтэй ББСБ-ууд /тэрбум төгрөгөөр/	21
Зураг 10 Өрийн бичгийн үлдэгдэл сүүлийн 5 жилийн байдлаар /тэрбум төгрөгөөр/.....	21

Зураг 11 Хувьцаат капиталын бүтэц сүүлийн 5 жилийн байдлаар /тэрбум төгрөгөөр/23

Зураг 12 Ашигт ажиллагааны үзүүлэлт /тэрбум төгрөгөөр/25

Товчилсон нэрсийн жагсаалт

Товчилсон нэр	Тайлбар
Хороо	Санхүүгийн зохицуулах хороо
ББСБ	Банк бус санхүүгийн байгууллага
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХК	Хувьцаат компани
СМА	Санхүүгийн мэдээллийн алба
ЗГВА	Гадаад валют арилжаа дагнан эрхэлдэг
УБ	Улаанбаатар хот
ХОН	Хөдөө орон нутаг
ГХО	Гадаадын хөрөнгө оруулалттай
ХНХ	Хувь нийлүүлсэн хөрөнгө
БХХО	Богино хугацаат хөрөнгө оруулалт
ӨБҮХХ	Өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгө
ӨБХ	Өмчлөх бусад хөрөнгө
ЗЖДХ	Зээлийн жигнэсэн дундаж хүү
ЗХШҮ	Зохистой харьцааны шалгуур үзүүлэлт

Банк бус санхүүгийн байгууллагын салбарын ерөнхий төлөв байдал

2021 оны II улирлын байдлаар Санхүүгийн зохицуулах хорооноос банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан 536 ББСБ байгаа нь өмнөх оны мөн үеэс 6 ББСБ буюу 1.1 хувиар буурсан үзүүлэлт юм. Эдгээр ББСБ-уудын 79 нь хөдөө орон нутагт үйл ажиллагаа эрхэлж байгаа бол гадаадын хөрөнгө оруулалттай 30 ББСБ, олон нийтэд хувьцаагаа санал болгосон 4 ББСБ байна.

Хүснэгт 1 ББСБ-уудын тоо мэдээлэл

	2017-II	2018-II	2019-II	2020-II	2021-II
Шинээр олгосон	20	10	5	12	7
Хүчингүй	5	5	6	8	3
Түдгэлзүүлсэн	17	15	6	25	1
Сэргээсэн	0	2	6	4	5
Нийт ББСБ	533	539	538	542	536
Үүнээс: ХОН	66	75	75	77	79
Үүнээс: ГХО	32	27	27	31	30
Салбар	126	190	235	278	308
Төлөөлөгч	4	4	7	9	8

2021 оны эхний хагас жилийн байдлаар нийт 7 хуулийн этгээдэд шинээр банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосон бол 3 ББСБ-ын тусгай зөвшөөрлийг хүчингүй болгож, 1 ББСБ-ын үйл ажиллагааг түдгэлзүүлж, 5 ББСБ-ын үйл ажиллагааг сэргээсэн байна.

Санхүүгийн үйлчилгээнд техник технологийг ашиглаж, шинэ төрлийн үйлчилгээ бий болгохоос гадна уламжлалт зээлийн үйлчилгээг хялбар, түргэн, шуурхай болгож буй онлайн зээлийн үйлчилгээг 2021 оны II улирлын байдлаар 22 ББСБ үзүүлж байна.

Хүснэгт 2 Банкны салбартай харьцуулсан ерөнхий үзүүлэлтүүд /тэрбум төгрөгөөр/

Үзүүлэлтүүд	2020.II	2021.II	Өсөлтийн хувь
Нийт хөрөнгө	1,862.2	2,263.0	21.5%
Банкны салбартай харьцуулахад хувиар	5.4%	5.6%	0.2%
Нийт өөрийн хөрөнгө	1,337.7	1,553.4	16.1%
Банкны салбартай харьцуулахад хувиар	43.8%	49.0%	5.2%
Нийт хувь нийлүүлсэн хөрөнгө	977.3	1,047.9	7.2%
Банкны салбартай харьцуулахад хувиар	134.1%	127.7%	-6.4%
Нийт зээл	1,307.3	1,571.9	20.2%
Банкны салбартай харьцуулахад хувиар	7.4%	8.0%	0.6%
Нийт орлого	200.2	220.0	9.9%
Нийт зарлага	123.6	135.3	9.5%
Цэвэр ашиг	76.6	84.8	10.7%

ББСБ-уудын нийт активын хэмжээ өмнөх оны мөн үеэс 400.8 тэрбум төгрөгөөр буюу 21.5 хувиар өсөж 2.3 их наяд төгрөгт хүрсэн нь банкны салбарын 5.6%-тай тэнцэж байна. Активын өсөлтийн 66.0 хувийг нийт зээлийн өсөлт, пассивын өсөлтийн 53.8 хувийг өөрийн хөрөнгийн өсөлт бүрдүүлж байна.

Харин хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ арилжааны банкнуудын хувь нийлүүлсэн хөрөнгөөс 1.3 дахин их байгаа нь ББСБ-ууд нь банктай харьцуулахад хадгаламж татдаггүй буюу өөрийн хөрөнгөндөө тулгуурлан үйл ажиллагаа эрхэлдэгтэй холбоотой.

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад нийт орлогын хэмжээ 9.9 хувиар буюу 19.8 тэрбум төгрөгөөр, нийт зардлын хэмжээ 9.5 хувиар буюу 11.7 тэрбум төгрөгөөр, цэвэр ашгийн хэмжээ 10.7 хувиар буюу 8.2 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 3 ББСБ-уудын эрхэлж буй үйл ажиллагаа

№	Үйл ажиллагааны нэр төрөл	ББСБ-ын тоо		Өөрчлөлт	
		2020-II	2021-II	тоо	хувь
	Нийт ББСБ-ын тоо	542	536	-6	-1.1%
1	Зээл	498	497	-1	-0.2%
	<i>Зээлийн үйл ажиллагаа дагнан эрхэлдэг</i>	337	329	-8	-2.4%
2	Факторинг	34	37	3	8.8%
3	Төлбөрийн баталгаа гаргах	20	21	1	5.0%
4	Төлбөр тооцооны хэрэгсэл гаргах	5	5	0	0.0%
5	Цахим төлбөр тооцоо мөнгөн гуйвуулга	33	36	3	9.1%
6	Гадаад арилжаа валютын	159	150	-9	-5.7%
	<i>Гадаад валютын арилжаа дагнан эрхэлдэг</i>	44	39	-5	-11.4%
7	Итгэлцэл	40	44	4	10.0%
8	Богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх	10	15	5	50.0%
9	Хөрөнгө оруулалт санхүүгийн чиглэлээр зөвлөгөө мэдээлэл өгөх	37	39	2	5.4%

Үйл ажиллагааны төрлөөр авч үзвэл 536 ББСБ 9 төрлийн үйл ажиллагааг тусгай зөвшөөрлийн хүрээнд эрхэлж байна. Нийт ББСБ-уудын 92.7% нь буюу 497 ББСБ зээлийн үйл ажиллагаа эрхэлж байгаа ба үүнээс 61.4% нь буюу 329 ББСБ дагнан эрхэлж байна. Харин гадаад валютын арилжааны үйл ажиллагаа эрхэлж байгаа 150 ББСБ байгаа нь нийт ББСБ-уудын 28.0 хувийг, гадаад валютын

арилжааны үйл ажиллагаа дагнан эрхэлж байгаа 39 ББСБ нийт ББСБ-уудын 7.3% бүрдүүлж байна.

Зээл болон гадаад валют арилжааны үйл ажиллагаа дагнан эрхэлдэг ББСБ-ын тоо өмнөх оны мөн үеэс харгалзан 2.4%, 11.4 хувиар буурч, бусад төрлийн үйл ажиллагааны тоо нэмэгдэж байгаа нь ББСБ-ууд үйл ажиллагааны цар хүрээгээ тэлж байгааг харуулж байна. Харин өмнөх оны мөн үеэс нэмэгдсэн үйл ажиллагааны төрлийг авч үзвэл богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх үйлчилгээ 50.0 хувиар, итгэлцлийн үйлчилгээ 10.0 хувиар, цахим төлбөр тооцоо мөнгөн гуйвуулгын үйлчилгээ 9.1 хувиар, факторинг 8.0 хувиар тус тус өссөн байна.

2021 оны эхний хагас жилийн тайлан мэдээний ирц 97.6% байна. Тайлан мэдээг ирүүлбэл зохих 536 ББСБ-аас 523 ББСБ улирлын тайлан мэдээг зохих ёсоор бүрэн ирүүлснийг холбогдох журмын дагуу хянаж, тайлангийн нэгтгэлд хамруулсан бөгөөд нэр бүхий 11 ББСБ өмнөх үеийн тайлан тэнцлээр, нэр бүхий 2 ББСБ эхлэлтийн тайлан тэнцлээр нэгтгэлд хамрагдлаа.

Хууль, тогтоомж болон журмын өөрчлөлт, хэрэгжилт

Банк бус санхүүгийн байгууллагын салбарт мөрдөгдөх дүрэм, журмуудыг хууль тогтоомжид нийцүүлэн шинээр боловсруулах, шинэчлэх, нэмэлт өөрчлөлт оруулах арга хэмжээний хүрээнд дараах дүрэм журмуудыг шинэчлэн Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгүүллээ.

- “Зээлийн батлан даалтын сангийн үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавих журам”-д өөрчлөлт оруулах тухай тогтоолыг 2021 оны 02 дугаар сарын 24-ний өдрийн Хорооны хуралдаанаар хэлэлцүүлэн, [65 дугаар тогтоолоор](#) батлуулсан ба Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд 2021 оны 3 дугаар сарын 02-ны өдөр хүлээн авсан.

- Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 441 дүгээр тогтоол /Банк бус санхүүгийн байгууллагын хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээ, үе шаттай нэмэгдүүлэх хуваарийг шинэчлэн батлах тухай/-ын хавсралтад өөрчлөлт оруулах тухай тогтоолыг 2021 оны 02 дугаар сарын 24-ний өдрийн Хорооны хуралдаанаар хэлэлцүүлэн, [66 дугаар тогтоолоор](#) батлуулсан ба Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд 2021 оны 3 дугаар сарын 02-ны өдөр хүлээн авсан.

- “Банк бус санхүүгийн байгууллагаас гаргах хаалттай өрийн бичгийг бүртгэх, түүнд хяналт тавих журам”-ыг боловсруулж, 2021 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн Хорооны хуралдаанаар хэлэлцүүлэн, [165 дугаар тогтоолоор](#) батлуулсан.

- Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын үед банк бус санхүүгийн байгууллагуудад хэрэгжүүлэх арга хэмжээний тухай (2021 оныг дуустал зээлийн гэрээнд 2 ба түүнээс дээш удаа өөрчлөлт оруулсан тохиолдолд ангилал бууруулан бүртгэх журмын үйлчлэлийг түр зогсоох мөн 60 хоног хүртэлх хугацаанд хэвийн ангилалд ангилан бүртгэнэ.) тогтоолыг боловсруулж, 2021 оны 6 дугаар сарын 23-ны өдрийн

Хорооны хуралдаанаар хэлэлцүүлэн, [262 дугаар тогтоолоор](#) батлуулсан.

“Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай” хуулийн 15 дугаар зүйлийн 15.4 дэх заалтын хэрэгжилт

2021 оны II улирлын байдлаар Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4-т заасны дагуу 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг хөндлөнгийн аудитаар баталгаажуулах үүргийг 85.9% буюу 458 ББСБ, нийтэд мэдээлэх үүргийг 432 ББСБ хэрэгжүүлсэн байна.

“Зээлийн мэдээллийн тухай” хуулийн хэрэгжилт

Зээлийн мэдээллийн тухай хуульд заасны дагуу зээлийн үйл ажиллагаа эрхлэх байгууллагууд Монголбанкны зээлийн мэдээллийн сантай хамтран ажиллах гэрээг байгуулан зээлдэгчийн талаарх мэдээлэл, лавлагааг зээлийн үйл ажиллагаандаа авч ашиглах үүрэгтэй. Монголбанкны ерөнхийлөгчийн 2020 оны 3 дугаар сарын 03-ны өдрийн А-57 дугаар тушаалаар “Монголбанкны зээлийн мэдээллийн сангийн журам”-ыг шинэчлэн баталсантай холбоотойгоор Монголбанкнаас мэдээлэл нийлүүлэгч байгууллагуудтай хамтран ажиллах гэрээг нэгдсэн журмаар шинэчлэн байгуулах ажлыг зохион байгуулж, тайлант улиралд зээлийн үйл ажиллагаа эрхэлж буй 497 ББСБ-ын 83.1% буюу 413 ББСБ гэрээгээ шинэчлэн байгуулсан байна.

“Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай” хуулийн хэрэгжилт

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д “Энэ хуулийн 4.1-д заасан этгээд 20 сая төгрөг, түүнээс дээш үнийн дүнтэй бэлэн мөнгөний болон гадаад төлбөр тооцооны гүйлгээний тухай мэдээллийг гүйлгээ хийгдсэнээс хойш ажлын таван өдрийн дотор батлагдсан маягт, журмын дагуу Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлэх үүрэгтэй.” гэж заасны дагуу нэр бүхий 140 ББСБ, 8,777 удаагийн тохиолдлоор, 718.4 тэрбум төгрөгийг, 7.2-т “Хөрөнгө, гүйлгээ,

гүйлгээ хийх оролдлогыг мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй, эсхүл гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлоготой холбоотой гэж сэжиглэсэн, эсхүл мэдсэн бол энэ хуулийн 4.1-д заасан этгээд энэ тухай 24 цагийн дотор сэжигтэй гүйлгээний тухай батлагдсан маягт, журмын дагуу Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлнэ.” гэж заасны дагуу нэр бүхий 5 ББСБ, 15 удаагийн тохиолдлоор, 342.2 сая төгрөгийг Монголбанкны СМА-нд тус тус мэдээлж, хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ хэрэгжүүлсэн байна.

“Зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг тогтоох, төвлөрүүлэх журам”-ын хэрэгжилт

2021 оны II улирлын байдлаар нийт 529 ББСБ-аас 1.3 тэрбум төгрөгийн зохицуулалт үйлчилгээний хөлс төлөхөөс 87.3% буюу 462 ББСБ 1.1 тэрбум төгрөгийн зохицуулалтын үйлчилгээний хөлсийг Хорооны холбогдох дансанд төвлөрүүлсэн байна.

Статистик үзүүлэлтүүд

2021 оны эхний хагас жилийн байдлаар давхардсан тоогоор 21,486 хувьцаа эзэмшигчдийн 536 ББСБ, 308 салбар нэгж, 8 төлөөлөгчийн газар, 3,713 ажилтантайгаар Монгол улсын 21 аймаг, 8 дүүрэгт давхардсан тоогоор 3.3 сая харилцагч, 748.3 мянган зээлдэгчид хүрч үйлчилж байна.

Хүснэгт 4 Харилцагчдын мэдээлэл

Статистик мэдээлэл	Дүн	Итгэлцэл	Уламжлалт	Финтек	ЗГВ	УБ	ХОН	ХК	ГХО
Нийт харилцагчдын тоо	3,292,164	1,470,106	307,191	2,984,973	19,591	3,279,739	12,425	1,261,130	121,997
Үүнээс: Эмэгтэй	1,880,818	807,333	160,201	1,720,617	11,290	1,874,129	6,689	694,655	65,706
Эрэгтэй	1,406,860	662,199	142,857	1,264,003	7,288	1,401,158	5,702	566,126	56,083
Хуулийн этгээд	4,486	574	4,133	353	1,013	4,452	34	349	208
Итгэмжлэгчдийн тоо	3,825	3,825	2,911	914	-	3,824	1	415	207
Өрийн бичиг авсан харилцагчдын тоо	550	408	287	263	-	548	2	213	135
Зээлдэгчдийн тоо	748,270	500,402	254,121	494,149	-	735,899	12,371	299,944	121,996
Үүнээс: Иргэн	746,419	499,689	252,354	494,065	-	734,082	12,337	299,836	121,773
Хуулийн этгээд	1,851	713	1,767	84	-	1,817	34	108	223
Хэвийн	671,682	443,011	229,610	442,072	-	661,333	10,349	260,286	111,051
Хугацаа хэтэрсэн	22,424	16,476	9,482	12,942	-	21,960	464	11,161	4,773
Чанаргүй:	54,164	40,915	15,029	39,135	-	52,606	1,558	28,497	6,172
-Хэвийн бус	7,195	4,618	4,265	2,930	-	6,538	657	1,359	1,143
-Эргэлзээтэй	15,343	12,719	3,733	11,610	-	15,215	128	10,727	1,889
-Муу	31,626	23,578	7,031	24,595	-	30,853	773	16,411	3,140
Зээлдэгчдийн насжилт	746,419	499,689	252,354	494,065	-	734,082	12,337	299,836	121,773
18-35 насны	447,435	305,609	148,129	299,306	-	442,700	4,735	201,506	93,704
36-45 насны	188,638	116,840	63,681	124,957	-	184,492	4,146	61,210	16,706
46-55 насны	82,600	56,803	30,612	51,988	-	80,180	2,420	28,463	8,990
55-аас дээш	27,746	20,437	9,932	17,814	-	26,710	1,036	8,657	2,373
Зээлдэгчдийн боловсрол	746,419	499,689	252,354	494,065	-	734,082	12,337	299,836	121,773
-Дээд	447,225	292,699	171,591	275,634	-	441,249	5,976	198,698	95,577
-Тусгай дунд	82,458	40,429	25,594	56,864	-	80,279	2,179	12,228	9,721
-Бүрэн дунд	175,036	131,628	44,705	130,331	-	171,935	3,101	76,781	13,646
-Дунд	31,397	25,450	8,259	23,138	-	30,633	764	8,460	2,665
-Бага	10,303	9,483	2,205	8,098	-	9,986	317	3,669	164

/Финтек ББСБ-ууд уламжлалт зээл давхар олгодог болно/

Харилцагчид, зээлдэгчид

Нийт харилцагчдын тоо өмнөх оны мөн үеэс 19.0 хувиар өсөж 3,292,164-д, зээлдэгчдийн тоо өмнөх оны мөн үеэс 67.8 хувиар өсөж 748,270-д хүрлээ. Зээлдэгчдийн тоо огцом өссөн нь аппликэйшн ашиглан бага дүнтэй богино хугацаатай хэрэглээний зээл олгодог ББСБ-ууд нэмэгдсэнтэй холбоотой.

Нийт харилцагчдын 90.7% буюу 2,984,973 нь, зээлдэгчдийн 66.0% буюу 494,149 нь санхүүгийн үйлчилгээнд техник технологийг ашиглаж /финтек/, онлайн зээлийн үйлчилгээ нэвтрүүлж буй ББСБ-уудын харилцагч, зээлдэгч байгаа бол нийт харилцагчдын 5.7% буюу 186,449, зээлдэгчдийн 17.8% буюу 133,379 нь уламжлалт ББСБ-ын харилцагч, зээлдэгч байна. Гадаад валют арилжааны үйлчилгээ дагнан эрхэлдэг ББСБ-уудын харилцагчид 19,591 буюу нийт харилцагчдын 0.6 хувийг бүрдүүлж байна.

Хүснэгт 5 Статистик мэдээлэл /5 жилээр/

Үзүүлэлтүүд	2017-II	2018-II	2019-II	2020-II	2021-II	Өөрчлөлт	
						Дүнгээр	Хувиар
Хувьцаа эзэмшигчдийн тоо	1,049	4,793	7,618	8,404	21,486	13,082	155.7%
Ажилчдын тоо	2,282	8,602	2,921	3,372	3,713	341	10.1%
Харилцагчдын тоо	1,353,143	1,423,597	2,348,014	2,766,913	3,292,164	525,251	19.0%
Зээлдэгчдийн тоо	65,449	150,542	360,345	445,984	748,270	302,286	67.8%
Зээлийн жигнэсэн дундаж хүү	3.5%	3.3%	3.4%	2.9%	2.9%	-	

Хувьцаа эзэмшигчид, ажилчид

Нийт хувьцаа эзэмшигчдийн тоо өмнөх оны мөн үеэс 2.6 дахин, оны эхнээс 2.4 дахин өсөж 21,486-д хүрлээ. Нийт хувьцаа эзэмшигчдийн 20,455 буюу 95.9% нь олон нийтэд хувьцаагаа санал болгосон ББСБ-уудын хувьцаа эзэмшигч байгаа бол 1,031 буюу 4.8% нь хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хувьцаа эзэмшигчид байна.

Хүснэгт 6 ББСБ-ын мэдээлэл

Статистик мэдээлэл	НИЙТ	Итгэлцэл	Уламжлалт	Финтек	ЗГВА	УБ	ХОН	ХК	ГХО
Хувьцаа эзэмшигчдийн тоо	21,486	19,697	2,554	18,932	64	21,298	188	20,455	1,629
Нийт ажилтнуудын тоо	3,713	1,402	2,726	987	95	3,488	225	246	401
Үүнээс: Эмэгтэй ажилтны тоо	2,161	772	1,621	540	55	2,015	146	148	224

Мөн хувьцаа эзэмшигчдийн 1,629 буюу 7.6% нь гадаадын хөрөнгө оруулалттай ББСБ-уудын хувьцаа эзэмшигчид байгаа бол 188 буюу 0.9% нь хөдөө орон нутгийн ББСБ-уудын хувьцаа эзэмшигчид байна.

Хөдөө орон нутгийн 79 ББСБ 5 төрлийн тусгай зөвшөөрлийн хүрээнд үйл ажиллагаа эрхэлж байна. Одоогоор үл хөдлөх эд хөрөнгө барьцаалахтай холбоотой санхүүгийн зуучлалын үйл ажиллагаа эрхэлж буй ББСБ байхгүй байна.

Хүснэгт 7 Тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа

	Нийт	Итгэлцэл	Уламжлалт	Финтек	ЗГВА	УБ	ХОН	ХК	ХХК	ГХО
ТЗ-гэй ББСБ-ын тоо	536	44	511	22	39	457	79	4	532	30
1 Зээл	497	44	475	22	-	420	77	4	493	30
2 Факторингийн үйлчилгээ	37	14	27	10	-	37	-	2	35	2
3 Төлбөрийн баталгаа гаргах	21	7	18	3	-	21	-	1	20	5
4 Төлбөр тооцооны хэрэгсэл гаргах	5	1	1	4	-	5	-	1	4	-
5 Цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ	36	11	26	10	-	36	-	2	34	1
6 Гадаад валютын арилжаа	150	24	139	11	39	142	8	3	147	9
7 Итгэлцлийн үйлчилгээ	44	44	33	11	-	43	1	3	41	4
8 Богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх	15	9	12	3	-	14	1	2	13	2
9 Хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөгөө, мэдээлэл өгөх	39	17	33	6	-	37	2	4	35	5

Тархалт

Улаанбаатар хотод нийт ББСБ-уудын 85.3% буюу 457 ББСБ, салбаруудын 68.5% буюу 211 салбар байршиж байна. Харин хөдөө орон нутагт нийт ББСБ-ын 14.7% буюу 79 ББСБ, салбаруудын 31.5% буюу 97 салбар бүртгэлтэй үйл ажиллагаа эрхэлж байна.

Зураг 1 ББСБ-уудын тархалт



2021 оны II улирлын байдлаар 79 ББСБ-ын 308 салбар бүртгэлтэй байна. Нийт салбарын 65.3 хувийг 14 ББСБ-ын 201 салбар бүрдүүлж байна.

Хүснэгт 8 Улаанбаатар хотын ББСБ-уудын тархалт

Дүүрэг	Үндсэн	Салбар	Нийт	Хувь
	457	211	668	100.0%
Сүхбаатар дүүрэг	155	31	186	28.6%
Чингэлтэй дүүрэг	131	32	163	24.5%
Баянгол дүүрэг	75	38	113	16.7%
Баянзүрх дүүрэг	53	50	103	15.1%
Хан-Уул дүүрэг	34	23	57	8.1%
Сонгинохайрхан дүүрэг	8	31	39	6.0%
Багануур дүүрэг	1	4	5	0.8%
Налайх дүүрэг		2	2	0.3%

ББСБ-ууд хөдөө орон нутгаас Орхон аймаг, Улаанбаатар хотоос Сүхбаатар дүүрэгт хамгийн ихээр төвлөрч үйлчилгээгээ хүргэж байна.

Хүснэгт 9 Хөдөө орон нутгийн ББСБ-уудын тархалт

Аймаг	Үндсэн	Салбар	Нийт	Хувь
	79	97	176	100%
Архангай аймаг	1	2	3	1.7%
Баян-Өлгий аймаг	3	2	5	2.8%
Баянхонгор аймаг	3	5	8	4.5%
Булган аймаг	2	-	2	1.1%
Говь-Алтай аймаг	1	-	1	0.6%
Говьсүмбэр аймаг	2	2	4	2.3%
Дархан-Уул аймаг	7	11	18	10.2%
Дорноговь аймаг	2	6	8	4.5%
Дорнод аймаг	5	7	12	6.8%
Дундговь аймаг	1	3	4	2.3%
Завхан аймаг	2	1	3	1.7%
Орхон аймаг	7	13	20	11.4%
Өвөрхангай аймаг	8	6	14	8.0%
Өмнөговь аймаг	2	11	13	7.4%
Сүхбаатар аймаг	5	3	8	4.5%
Сэлэнгэ аймаг	5	6	11	6.3%
Төв аймаг	14	3	17	9.7%
Увс аймаг	3	4	7	4.0%
Ховд аймаг	1	3	4	2.3%
Хөвсгөл аймаг	3	5	8	4.5%
Хэнтий аймаг	2	4	6	3.4%

Активын бүтэц, бүрэлдэхүүн, өөрчлөлт


2021 оны II улирлын байдлаар банк бус санхүүгийн салбарын нийт хөрөнгө 2.3 их наяд төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 21.5 хувиар буюу 400.8 тэрбум төгрөгөөр өсжээ. Активын өсөлтийн 66.0 хувийг зээлийн өсөлт бүрдүүлж байна. Активын үзүүлэлтүүдийг өмнөх оны мөн үе болон оны эхэнтэй харьцуулж үзвэл:

Хүснэгт 10 Активын үзүүлэлтүүд /сая төгрөгөөр/

Активын үзүүлэлтүүд	2020.II дүн	Нийт дүнд эзлэх хувь	2021.II дүн	Нийт дүнд эзлэх хувь	Өөрчлөлт	
					дүн	хувь
Эргэлтийн хөрөнгө	1,791,441.5	96.2%	2,178,652.0	96.3%	387,210.5	21.6%
Мөнгөн хөрөнгө	395,258.5	21.2%	443,862.0	19.6%	48,603.5	12.3%
Богино хугацаат хөрөнгө оруулалт (цэврээр)	10,263.3	0.6%	19,654.4	0.9%	9,391.1	91.5%
Зээл (цэврээр)	1,218,524.8	65.4%	1,455,865.9	64.3%	237,341.1	19.5%
Нийт зээл	1,307,300.6	70.2%	1,571,878.2	69.5%	264,577.6	20.2%
(Зээлийн эрсдэлийн сан)	88,775.8	4.8%	116,012.3	5.1%	27,236.5	30.7%
Факторингийн тооцооны авлага (цэврээр)	2,904.0	0.2%	11,888.3	0.5%	8,984.3	309.4%
Өмчлөх бусад үл хөдлөх болон өмчлөх бусад хөрөнгө (цэврээр)	12,872.6	0.7%	13,582.2	0.6%	709.6	5.5%
Бусад хөрөнгө	151,618.3	8.1%	233,799.3	10.3%	82,181.0	54.2%
Эргэлтийн бус хөрөнгө	70,713.4	3.8%	84,316.7	3.7%	13,603.3	19.2%
Үндсэн (биет) ба биет бус хөрөнгө	87,703.7	4.7%	107,617.2	4.8%	19,913.5	22.7%
(Хуримтлагдсан элэгдэл)	-16,990.4	0.9%	-23,300.5	-1.0%	-6,310.1	37.1%
Нийт хөрөнгийн дүн	1,862,154.9	100.0%	2,262,968.8	100.0%	400,813.9	21.5%

Сүүлийн 5 жилийн активын үзүүлэлтийг харвал салбарын нийт актив 2017 оны мөн үед 855.8 тэрбум төгрөг байсан бол 2021 оны II улирлын байдлаар 2.6 дахин өсөж 2.3 их наяд төгрөгт хүрчээ. Энэ нь цэвэр зээлийн үлдэгдэл 1.9 дахин өссөнтэй холбоотой.

Зураг 2 Активын үзүүлэлтүүд сүүлийн 5 жилийн байдлаар /тэрбум төгрөгөөр/



Салбарын нийт хөрөнгийн 79.2% нь 2.5 тэрбум төгрөг ба түүнээс дээш хөрөнгөтэй 193 ББСБ, 9.8% нь 1.9-2.5 тэрбум төгрөг хүртэлх активтай 102 ББСБ байгаа бол нийт салбарын хөрөнгийн 11.0 хувийг 1.9 тэрбум төгрөг хүртэлх активтай 241 ББСБ-ын хөрөнгө бүрдүүлж байна.

Хүснэгт 11 Активын интервал /тэрбум төгрөгөөр/

Интервал	Нийт		Эзлэх хувь		Дархан, Эрдэнэт		Бусад аймаг, сумд		ЗГВА	
	Актив	ББСБ тоо	Актив	ББСБ тоо	Актив	ББСБ тоо	Актив	ББСБ тоо	Актив	ББСБ тоо
5.0 тэрбумаас дээш	1,394.1	76	61.6%	14.2%	5.6	1	-	-	-	-
2.5-5.0 тэрбум	397.7	117	17.6%	21.8%	7.0	2	4.3	1	-	-
1.9-2.5 тэрбум	221.2	102	9.8%	19.0%	-	-	2.0	1	-	-
1.4-1.9 тэрбум	180.6	111	8.0%	20.7%	3.0	2	1.7	1	1.8	1
0.6-1.4 тэрбум	46.0	41	2.0%	7.6%	4.3	5	9.5	10	3.9	4
0.6 тэрбум хүртэлх	23.3	89	1.0%	16.6%	1.0	3	12.8	51	9.0	34
НИЙТ	2,263.0	536	100.0%	100.0%	20.8	13	30.2	64	14.7	39

Мөнгөн хөрөнгө


Мөнгөн хөрөнгийн 36.4% нь бэлэн мөнгө хэлбэрээр, 32.9% нь банк, санхүүгийн байгууллагын харилцах дансанд 30.8% нь банк, санхүүгийн байгууллагын хадгаламжийн дансанд байршиж байна.

Хүснэгт 12 Мөнгөн хөрөнгийн бүтэц /тэрбум төгрөгөөр/

	Нийт	Итгэлцэл	Уламжлалт	Финтек	ЗГВА	УБ	ХОН	ХК	ГХО
МӨНГӨН ХӨРӨНГӨ	443.9	102.5	382.7	61.2	14.2	432.5	11.3	21.7	47.5
Бэлэн мөнгө	157.6	8.1	154.9	2.7	12.0	150.6	7.0	0.0	5.7
Харилцах	173.4	43.8	135.2	38.2	2.1	169.9	3.5	18.6	29.0
Хадгаламж	112.9	50.7	92.6	20.3	0.1	112.1	0.8	3.1	12.9

ББСБ-уудын мөнгөн хөрөнгийн бүтцийг авч үзвэл уламжлалт үйл ажиллагаа явуулж байгаа ББСБ-уудын мөнгөн хөрөнгийн 40.5%, финтек ББСБ-уудын мөнгөн хөрөнгийн 4.5%, эрхэлж буй үйл ажиллагааны онцлогоос хамаарч валют арилжаа дагнан эрхэлж буй ББСБ-уудын 84.8% нь бэлэн мөнгө хэлбэрээр тус тус байршиж байна.

Зураг 3 Мөнгөн хөрөнгийн бүтэц сүүлийн 5 жилийн байдлаар /тэрбум төгрөгөөр/



Богино хугацаат хөрөнгө оруулалт

Богино хугацаат хөрөнгө оруулалт өмнөх оны мөн үеэс 91.5% буюу 9.2 тэрбум төгрөгөөр өсөж, 2021 оны II улирлын байдлаар 23 ББСБ 19.7 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын үлдэгдэлтэй гарсан байна.

Богино хугацаат хөрөнгө оруулалтын 45.1% буюу 8.9 тэрбум төгрөгийг арилжааны үнэт цаас, 55.1% буюу 10.8 тэрбум төгрөгийг хөрөнгө оруулалтын үнэт цаас бүрдүүлж байна. Төрлөөр авч үзвэл 64.3% буюу 12.6 тэрбум төгрөг нь хувьцаа, 34.4% буюу 6.8 тэрбум төгрөг нь өрийн бичгээр, 1.6% буюу 306.1 сая төгрөг нь бусад үнэт цаасаарх хөрөнгө оруулалт байна.

Хүснэгт 13 Богино хугацаат хөрөнгө оруулалтын бүтэц /сая төгрөгөөр/

	Дүн	Итгэлцэл	Уламжлалт	Финтек	ЗГВ	УБ	ХОН	ХК	ГХО
БХХО (ЦЭВРЭЭР)	19,654.4	18,458.4	10,247.6	9,406.7	1.0	18,973.7	680.6	14,979.0	8,130.7
Хувьцаа	12,631.8	11,560.9	7,841.1	4,790.6	1.0	11,952.1	679.6	10,512.1	6,065.9
Өрийн бичиг	6,755.9	6,636.7	2,400.5	4,355.4	-	6,755.9	-	4,165.7	2,064.9
Бусад	306.1	301.1	5.0	301.1	-	306.1	-	301.1	-
Хөрөнгө оруулалтын үнэт цаас	8,866.7	8,826.9	6,422.3	2,444.4	-	8,866.7	-	6,354.9	6,065.9
Арилжааны үнэт цаас	10,828.0	9,671.9	3,825.3	7,002.7	1.0	10,147.4	680.6	8,624.1	2,064.9

Тайлант улиралд богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх тусгай зөвшөөрөлтэй 15 ББСБ бүртгэлтэй байгаа хэдий ч 23 ББСБ санхүүгийн тайлангаар богино хугацаат хөрөнгө оруулалтын үлдэгдэлтэй гарсан ба эдгээрийн 9 ББСБ нь тусгай зөвшөөрөлтэй байна.

Засгийн газрын бондыг эрсдэлгүй гэж үзэн СЗХ-оос тухайн төрлийн бондыг тусгай зөвшөөрөлгүйгээр авах боломжтой гэж үзсэн хэдий ч санхүүгийн тайлангийн Засгийн

газрын үнэт цаас хэсэгт 1 ББСБ 1.0 сая төгрөгийн үнэт цаас бүртгэсэн байна. Иймээс 6 ББСБ тусгай зөвшөөрөлгүй энэхүү үйл ажиллагааг эрхэлсэн, 7 санхүүгийн тайланд буруу дансанд бүртгэл хөтөлсөн байна.

Факторингийн тооцооны авлага

Нийт активын өсөлтийн хамгийн өндөр өсөлтийн хувийг факторингийн тооцооны авлагын өсөлт үзүүлсэн байна. Өмнөх оны мөн үеэс 4.1 дахин буюу 9.0 тэрбум төгрөгөөр өсөж 11.9 тэрбум төгрөгт хүрчээ. Факторингийн үйлчилгээний тусгай зөвшөөрөлтэй ББСБ-уудын тоо өмнөх оны мөн үетэй харьцуулахад нэмэгдсэн хэдий ч 2021 оны II улирлын байдлаар 10 ББСБ 293.5 сая төгрөгийн хугацаа хэтэрсэн болон чанаргүй факторингийн үлдэгдэлд 62.1 сая төгрөгийн эрсдэлийн сан байгуулж, 11.9 тэрбум төгрөгийн цэвэр үлдэгдэлтэй гарчээ.

Факторингийн тусгай зөвшөөрөлтэй 37 ББСБ-уудын 27 ББСБ нь тусгай зөвшөөрөл олгосноос хойш үйл ажиллагаа эрхлэхгүй байгаа нь учир дутагдалтай байна.

Хүснэгт 14 Факторингийн тооцооны авлагын ангилал /сая төгрөгөөр/

Нийт факторингийн тооцооны авлага	2020-II		2021-II		Өөрчлөлт	
	Нийт дүн	Эзлэх хувь	Нийт дүн	Эзлэх хувь	Дүн	Хувь
	2,924.8	100.0%	11,950.4	100.0%		
Хэвийн	2,858.6	97.7%	11,656.9	97.5%	8,798.4	307.8%
Хугацаа хэтэрсэн	39.6	1.4%	198.8	1.7%	159.2	401.5%
Чанаргүй	26.6	0.9%	94.7	0.8%	68.1	255.9%
Хэвийн бус	6.3	0.2%	34.0	0.3%	27.7	436.5%
Эргэлзээтэй	6.1	0.2%	34.1	0.3%	28.0	461.6%
Муу	14.2	0.5%	26.6	0.2%	12.4	87.2%
(Факторингийн авлагын эрсдэлийн сан)	20.8	0.7%	62.1	0.5%	41.3	198.4%

Өмчлөх бусад үл хөдлөх болон өмчлөх бусад хөрөнгө

Өмчлөх бусад үл хөдлөх болон өмчлөх бусад хөрөнгийн дүн өмнөх оны мөн үеэс 709.6 сая төгрөг буюу 5.5 хувиар өсөж 13.6 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй гарчээ.

Хүснэгт 15 ӨБҮХХ болон ӨБХ-ийн бүтэц /сая төгрөгөөр/

	Нийт	Итгэлцэл	Уламжлалт	Финтек	УБ	ХОН	ХК	ХХК	ГХО
ӨБҮХХ БОЛОН ӨБХ (ЦЭВРЭЭР)	13,582.2	3,299.4	11,986.7	1,595.5	13,579.2	3.0	246.5	13,335.7	1,798.1
Өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгө	16,279.6	4,806.6	14,528.8	1,750.8	16,279.6	-	1,546.7	14,732.9	2,587.7
(ӨБҮХХ-ийн болзошгүй эрсдэлийн сан)	6,015.8	2,648.3	5,617.9	397.9	6,015.8	-	1,300.2	4,715.6	1,592.8
Өмчлөх бусад хөрөнгө	3,318.4	1,141.1	3,075.8	242.6	3,315.4	3.0	-	3,318.4	803.2

Зээл

Нийт зээлийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 20.2% буюу 264.6 тэрбум төгрөгөөр өсөж 2021 оны II улирлын байдлаар 1.6 их наяд төгрөгт хүрсэн бөгөөд үүнд 116.0 тэрбум төгрөгийн эрсдэлийн сан байгуулж, 1.5 их наяд төгрөгийн цэвэр зээлийн үлдэгдэлтэй гарсан байна.

Хүснэгт 16 Зээлийн бүтэц /тэрбум төгрөгөөр/


	Нийт	Итгэлцэл	Уламжлалт	Финтек	УБ	ХОН	ХК	ХХК	ГХО
ЗЭЭЛ (ЦЭВРЭЭР)	1,455.9	716.8	1,063.0	392.9	1,423.7	32.1	174.8	1,281.1	223.9
Нийт зээл	1,571.9	762.9	1,163.0	408.8	1,534.4	37.5	181.8	1,390.0	237.3
Хэвийн	1,373.1	685.9	991.4	381.8	1,342.5	30.6	172.6	1,200.5	214.9
Хугацаа хэтэрсэн	46.0	16.2	40.5	5.6	45.5	0.6	1.8	44.2	5.5
Чанаргүй:	152.7	60.8	131.2	21.5	146.4	6.3	7.4	145.3	16.9
-Хэвийн бус	34.4	14.9	29.1	5.3	33.9	0.5	1.9	32.5	3.8
-Эргэлзээтэй	29.4	9.5	25.0	4.4	28.3	1.1	1.0	28.3	3.2
-Муу	88.9	36.3	77.1	11.8	84.3	4.7	4.5	84.5	9.8
(Зээлийн эрсдэлийн сан)	116.0	46.0	100.0	16.0	110.7	5.3	7.0	109.0	13.4
Нийт зээл (төгрөгийн)	1,517.0	729.0	1,120.3	396.7	1,479.5	37.5	161.4	1,355.6	212.1
Нийт зээл (валютын)	54.8	33.8	42.7	12.1	54.8	0.0	20.4	34.4	25.2
Зээлдэгчдийн тоо	748,270	500,402	254,121	494,149	735,899	12,371	299,944	448,326	121,996
- Иргэн	746,419	499,689	252,354	494,065	734,082	12,337	299,836	446,583	121,773
- Хуулийн этгээд	1,851	713	1,767	84	1,817	34	108	1,743	223

/Финтек ББСБ-ууд уламжлалт зээл давхар олгодог болно/

Тайлант улиралд ББСБ-ууд 1.1 их наяд төгрөгийн зээлийг 2.9 хувийн жигнэсэн дундаж хүүтэйгээр олгож, 885.8 тэрбум төгрөгийн зээл эргэн төлөгдөж, 2021 оны II улирлын байдлаар 748,270 зээлдэгчийн 1.5 их наяд төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй гарсан байна.


Нийт зээлийн үлдэгдлийн 87.4 хувийг буюу 1,373.1 тэрбум төгрөгийг хэвийн зээл, 2.9 хувийг буюу 46.0 тэрбум төгрөгийг хугацаа хэтэрсэн зээл, 9.7 хувийг буюу 152.7 тэрбум төгрөг чанаргүй зээлийн үлдэгдэл бүрдүүлж байна.

Зураг 4 Зээлийн багцын чанар /тэрбум төгрөгөөр/



Нийт зээлд эзлэх хугацаа хэтэрсэн зээлийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 1.8 пунктээр буурсан бол хэвийн болон чанаргүй зээлийн хэмжээ харгалзан 0.8, 1.0 пунктээр тус тус өссөн байна. Хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлийн 198.7 тэрбум төгрөгийн үлдэгдлийн 58.4%-д буюу 116.0 тэрбум төгрөгийн зээлийн эрсдэлийн сан байгуулсан байна.

Зураг 5 Зээлийн багцын чанар /хувиар/



Сангийн сайд, Үндэсний статистикийн хорооны дарга нарын хамтарсан 2018 оны 12-р сарын 31-ний өдрийн 319/А/16 тоот тушаалаар баталсан “Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал”-аар нийт олгосон зээлийн 64.9% буюу 734.2 тэрбум төгрөг нь бусад ангилалд /ихэвчлэн хэрэглээний зээл/, 10.1% буюу 114.2 тэрбум төгрөг нь бөөний

болон жижиглэн худалдааны салбарт олгогдсон бол нийт төлөгдсөн зээлийн 65.8% буюу 585.6 тэрбум төгрөг нь бусад ангиллын зээлээс, 11.7% буюу 103.8 тэрбум төгрөг нь бөөний болон жижиглэн худалдааны салбарт олгосон зээлээс эргэн төлөгджээ.


Олгосон зээлийн 88.2% буюу 997.8 тэрбум төгрөгийн зээлийг иргэдэд, 11.8% буюу 133.9 тэрбум төгрөгийн зээлийг хуулийн этгээдэд олгосон байгаа бол 88.7% буюу 785.9 тэрбум төгрөг нь иргэдээс, 11.3% нь буюу 99.9 тэрбум төгрөг нь хуулийн этгээдээс эргэн төлөгдсөн байна.

Хүснэгт 17 Олгосон болон төлөгдсөн зээл салбараар /сая төгрөгөөр/

№	Зээлийн эдийн засгийн ангилал	Олгосон зээл		Төлөгдсөн зээл		Зээлийн үлдэгдэл	
		Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь
1.	Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	10,472.6	0.9%	6,377.6	0.7%	22,748.9	1.4%
2.	Уул уурхай, олборлолт	27,054.2	2.4%	17,217.3	1.9%	48,645.0	3.1%
3.	Боловсруулах үйлдвэрлэл	17,193.8	1.5%	15,234.1	1.7%	26,285.0	1.7%
4.	Цахилгаан, хий, уур, агааржуулалтын хангамж	1,634.4	0.1%	967.2	0.1%	4,482.4	0.3%
5.	Усан хангамж, бохир ус, хог хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа	655.7	0.1%	523.1	0.1%	2,967.1	0.2%
6.	Барилга	71,139.4	6.3%	57,119.9	6.4%	180,414.5	11.5%
7.	Бөөний болон жижиглэн худалдаа	114,184.9	10.1%	103,761.9	11.7%	218,383.1	13.9%
8.	Машин мотоциклийн засвар үйлчилгээ	50,810.2	4.5%	27,945.6	3.2%	61,790.3	3.9%
9.	Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	8,419.1	0.7%	8,505.1	1.0%	14,970.6	1.0%
10.	Байр сууц болон хоол хүнсээр үйлчлэх үйл ажиллагаа	22,429.3	2.0%	21,959.9	2.5%	71,789.9	4.6%
11.	Мэдээлэл холбоо	6,664.3	0.6%	4,424.1	0.5%	8,787.0	0.6%
12.	Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	22,907.9	2.0%	13,215.1	1.5%	31,108.0	2.0%
13.	Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	6,373.5	0.6%	4,958.4	0.6%	14,197.4	0.9%
14.	Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	4,153.2	0.4%	934.6	0.1%	5,655.1	0.4%
15.	Захиргааны болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	6,755.3	0.6%	7,270.4	0.8%	12,345.7	0.8%
16.	Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	14,286.2	1.3%	767.8	0.1%	1,335.0	0.1%
17.	Боловсрол	4,927.2	0.4%	4,917.9	0.6%	9,796.1	0.6%
18.	Хүний эрүүл мэнд, нийгмийн үйл ажиллагаа	7,451.6	0.7%	7,068.3	0.8%	15,644.1	1.0%
19.	Бусад	734,221.9	64.9%	582,629.9	65.8%	820,532.6	52.2%
Иргэнд олгосон зээл		997,814.1	88.2%	785,915.9	88.7%	1,339,328.6	85.2%
Хуулийн этгээдэд олгосон зээл		133,920.7	11.8%	99,882.1	11.3%	232,549.5	14.8%
НИЙТ		1,131,734.8	100.0%	885,798.1	100.0%	1,571,878.2	100.0%

Тайлант улиралд олгосон 1.1 их наяд төгрөгийн зээлийг хугацааны ангилалаар харвал 1-2.5 жилийн хугацаатай олгосон зээл нийт зээлийн 25.8 хувийг, 6-12 сарын хугацаатай олгосон зээл нийт зээлийн 21.3 хувийг буюу хамгийн өндөр хувийг бүрдүүлж байна.

Зураг 6 Олгосон зээл /хугацааны ангилалаар/



